



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И мэйл: ub@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn

2024.03.15 № 561
танай _____-ны № _____-т

ХҮНС ХАНГАМЖ ТӨВ ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Д.ИДЭРЗАЯА ТАНАА

Хүнс хангамж төв ОНӨААТҮГ-ын 2023 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын тайлан, санал дүгнэлтийг хүргүүлж байна.

Хавсралт . 2 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

002033351

D:\Desktop\2024\Word\Явсан бичиг\2024.03.15.Huns.hangamj.A5.docx

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хүнс хангамж төв ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/16/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Солид Юнити Аудит ХХК Гүйцэтгэх захирал: Э.Мөнхтогтох Утас: 99063227 Цахим хаяг: munkhtogtokh.e@solidunity.mn Аудитын менежер: Д.Нар-Од Утас: 99091993 Цахим хаяг: narod.d@solidunity.mn Аудитор: Ү.Цэцэгмаа Утас: 99095173 Цахим хаяг: tsetsegmaa.u@solidunity.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.Хараат бус аудиторын дүгнэлт.....	1
Асуудлыг онцолсон хэсэг	1
Аудитын гол асуудал.....	1
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	1
3.Санхүүгийн тайлангийн тодруулга	6
4.Аудитын тайлан.....	11
4.1 Ерөнхий зүйл.....	11
4.2 Материаллаг байдал	11
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	12
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
4.5.1 Завсрын аудитын талаар	13
5.Аудитын илрүүлэлт	14
5.2 Зөвлөмж.....	15
6.Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
ББӨ	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НТАГ	Нийслэлийн төрийн аудитын газар
ТӨХГ	Төрийн өмчийн харилцааны газар
ОАТ	Орлогын албан татвар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024. 03.15 № 502
танай _____-ны № _____-т

ХҮНС ХАНГАМЖ ТӨВ
ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Д.ИДЭРЗАЯА ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хүнс хангамж төв ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Хүнс хангамж төв ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Ирээдүйд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахад нөлөөлөх, эргэлзээ төрүүлж байгаа нөхцөл байдал аудит хийх шалгалтын явцад илрээгүй ба материаллаг байдлын түвшинд хүрсэн алдаа зөрчил илрээгүй байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд Нийслэлийн засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн А/1119 тоот захирамжаар баталсан нийт 25 ажилтан, үүнд 1 удирдах, 22 гүйцэтгэх, 2 үйлчилгээний ажилтнаас гүйцэтгэх албан тушаалд 18 ажилтан ажиллаж батлагдсан бүтэц орон тооноос 3 ажилтан дутуу ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Байгууллагын 2023 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 26 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 93.2 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	70,388,317.76	114,116,679.27
1.1.2	Дансны авлага	5,164,719.87	12,419,135.09
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	161,149.95	-
1.1.4	Бусад авлага	-	3,562,824.19
1.1.6	Бараа материал	60,952,046.25	58,381,442.45
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	164,130.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	136,666,233.83	188,644,211.00
1.2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
1.2.1	Үндсэн хөрөнгө	370,750,241.93	355,004,221.71
1.2.2	Биет бус хөрөнгө	34,675,460.00	34,675,460.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	405,425,701.93	389,679,681.71
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	542,091,935.76	578,323,892.71
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	11,822,910.00	80,000.00
2.1.1.3	Татварын өр	242,184,720.88	79,552,352.68
2.1.1.4	НДШ-ийн өглөг	1,047,361.11	609,167.97
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	262,869,045.00	6,571,726.12
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	530,652.44
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	517,924,036.99	87,343,899.21
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр төлбөр	-	1,645,007.84
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	-	246,439,729.76
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	248,084,737.60
2.2	ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН	517,924,036.99	335,428,636.81
2.3	ЭЗДИЙН ӨМЧ		
2.3.1	Өмч-Төрийн	167,629,728.30	167,629,728.30
2.3.6	Дахин үнэлгээний нэмэгдлийн нөөц	-	14,793,440.50
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	14,675,460.00	14,675,460.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(158,137,289.53)	45,796,627.10
2.3.9.1	Тайлант үеийн ашиг (алдагдал)	167,369,313.63	250,543,698.51
2.3.9.2	Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг (алдагдал)	(325,506,603.16)	(204,747,071.41)
2.3.11	Эздийн өмчийн дүн	24,167,898.77	242,895,255.90
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	542,091,935.76	578,323,892.71

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	5,345,201,002.72	6,684,582,316.57
2	Борлуулалтын өртөг	(4,673,920,531.87)	(5,820,729,571.61)
3	Нийт ашиг (алдагдал)	671,280,470.85	863,852,744.96
4	Хүүний орлого	-	709,142.19
5	Бусад орлого	1,046,273.81	12,564,453.35
6	Борлуулалт маркетингийн зардал	(161,144,436.19)	(262,680,298.51)
7	Ерөнхий ба удирдлагын зардал	(300,735,187.78)	(329,856,290.22)
8	Бусад зардал	(2,730,000.00)	(5,124,890.36)
9	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(21,447,883.31)	54,545.46
10	Татвар төлөхийн өмнөх ашиг	186,269,237.38	279,519,406.87
11	Орлогын татварын зардал	(18,899,923.74)	(28,731,477.50)
12	Татварын дараах ашиг (алдагдал)	167,369,313.64	250,787,929.37
13	НИЙТ ҮР ДҮН	167,369,313.64	250,787,929.37

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Дахин үнэлгээний нэмэгдлийн нөөц	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
1	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	167,629,728.30	14,675,460.00	-	(325,506,603.16)	(143,201,414.86)
2	Тайлант үеийн үр дүн	-	-	-	167,369,313.63	167,369,313.63
6	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	167,629,728.30	14,675,460.00	-	(158,137,289.53)	24,167,898.77
7	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	167,629,728.30	14,675,460.00	-	(158,137,289.53)	24,167,898.77
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	3,356,777.22	3,356,777.22
9	Зарласан ногдол ашиг	-	-	-	(50,210,790.00)	(50,210,790.00)
10	Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	14,793,440.50	-	14,793,440.50
11	Тайлант үеийн үр дүн	-	-	-	250,787,929.37	250,787,929.37
12	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	167,629,728.30	14,675,460.00	14,793,440.50	45,796,627.06	242,895,255.86

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	5,887,747,836.05	7,351,099,170.99
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	5,883,722,611.70	7,341,873,848.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	4,025,224.35	9,225,322.99
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,842,796,547.23	7,262,181,099.48
1.2.1	Ажиллагсдад төлсөн мөнгө	234,855,872.92	325,414,392.03
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	75,949,000.00	97,684,567.52
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	5,162,121,640.57	6,056,647,987.22
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	84,798,795.95	63,854,734.26
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	27,373,300.00	23,901,250.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн мөнгө	225,028,513.37	671,266,167.80
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	436,600.00	218,840.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	32,232,824.42	23,193,160.65
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	44,951,288.82	88,918,071.51
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
3.1	Мөнгөн зарлагын дүн (-)	-	45,189,710.00
3.1.1	Төлсөн ногдол ашиг	-	45,189,710.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(45,189,710.00)
4	БУХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	44,951,288.82	43,728,361.51
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	25,437,028.94	70,388,317.76
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	70,388,317.76	114,116,679.27

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(мянган төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2022 он	2023 он		Зөрүү	Хувь
		Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Борлуулалтын орлого	5,345,201.0	8,908,005.7	6,684,582.3	2,223,423.4	75.0
2	Үйл ажиллагааны бусад орлого	1,046.3	4,500.0	13,328.1	(8,828.1)	296.2
Нийт орлого		5,346,247.3	8,912,505.7	6,697,910.5	2,214,595.2	75.2
3	Борлуулалтын өртөг	4,673,920.5	8,000,279.9	5,820,729.6	2,179,550.3	72.8
4	Цалин	288,185.8	546,765.8	399,786.2	146,979.6	73.1
5	НДШ	36,147.9	68,345.7	49,919.0	18,426.7	73.0
6	Шуудан холбоо	5,007.3	7,020.0	4,312.1	2,707.9	61.4
7	Цахилгааны зардал	5,011.1	12,124.6	5,025.8	7,098.8	41.5
8	Шатахууны зардал	22,375.6	32,852.8	17,088.2	15,764.6	52.0
9	Бичиг хэргийн зардал	3,555.5	4,952.0	3,274.1	1,677.9	66.1
10	Хог хаягдлын зардал	360.0	360.0	840.0	(480.0)	28.9
11	Сэлбэг хэрэгслийн зардал	4,044.4	6,800.0	12,532.2	(5,732.2)	233.3
12	Хангамжийн материалын зардал	4,542.8	-	7,584.7	(7,584.7)	100.0
13	Хөдөлмөр хамгааллын хувцас	-	6,620.0	-	6,620.0	(100.0)
14	Ашиглалтын зардал	3,377.9	7,569.0	2,188.8	5,380.2	28.9
15	Түрээсийн зардал	44,590.0	50,940.0	45,380.0	5,560.0	89.1
16	Засвар үйлчилгээ	2,261.8	3,500.0	798.5	2,701.5	22.8
17	Бусад зардал	8,622.2	13,452.0	10,633.5	2,818.5	79.0
18	Элэгдлийн зардал	33,207.6	36,533.7	30,539.5	5,994.2	83.6
19	Сургалтын зардал	589.8	9,500.0	2,634.2	6,865.8	27.7
20	Албан томилолтын зардал	-	8,000.0	-	8,000.0	(100.0)
21	Шагнал урамшуулал	-	8,000.0	-	8,000.0	(100.0)
Үндсэн үйл ажиллагааны зардлын дүн		462,819.8	823,335.6	592,536.6	230,799.0	72.0
22	Үйл ажиллагааны бус зардал	2,730.0	18,800.0	5,124.9	13,675.1	27.3
23	Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	21,447.9	-	-	-	-
Нийт зардлын дүн		5,160,918.2	8,842,415.5	6,418,391.1	2,424,024.4	72.6
24	Татвар төлөхийн өмнөх ашиг	186,259.2	70,090.2	279,519.4	(209,429.2)	398.8
25	Татварын зардал	18,899.9	8,890.0	28,731.5	(19,841.5)	323.2
26	Тайлант үеийн цэвэр ашиг	116,369.3	61,200.2	250,787.9	(189,587.7)	409.8
27	Орлогын нэг төгрөгт ногдох зардал	0.96	0.99	0.96	1.09	96.6

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хүнс хангамж төв ОНӨААТҮГ нь эрхэм зорилгоо “Нийслэлийн сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулиудыг эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан, баталгаатай чанартай хүнсний бараа бүтээгдэхүүнээр тасралтгүй хангахад оршино” гэж тодорхойлжээ.

Хүнс хангамж төв ОНӨААТҮГ-ын дүрэмд байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Үндэсний үйлдвэрлэлээ дэмжиж аюулгүй, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, баталгаажсан бүтээгдэхүүнээр Сонгинохайрхан дүүргийн сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулиудыг хангах үүднээс гол нэрийн бараа, бүтээгдэхүүнийг үйлдвэрээс шууд нийлүүлэх;
- Стандартын шаардлага хангасан бусад нэрийн импортоор орж ирсэн хүнсний бүтээгдэхүүнийг зах зээлийн боломжит үнээр сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулиудад нийлүүлэх;
- Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуульд нийлүүлж байгаа бараа бүтээгдэхүүнд гарал үүсэл, мэргэжлийн байгууллагын шинжилгээний дүгнэлт хийлгэж байх;
- Тус байгууллага нь үйл ажиллагааны үндсэн чиглэлийн хүрээнд туслах аж ахуй эрхэлж болно. Үүнд: мал аж ахуй, хүнсний ногоо тариалах, мах, ногоо ангилах, савлах, жижиг үйлдвэр байгуулах, нийтийн хоолны тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Хүнс хангамж төв ОНӨААТҮГ нь Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Тэргүүлэгчдийн тогтоол, Нийслэлийн засаг даргын захирамж, мөрийн хөтөлбөр, Нийслэлийн засаг даргатай байгуулсан үр дүнгийн болон хариуцлагын гэрээ, холбогдох бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоол "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай";
- Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоол "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай";
- Засгийн газрын 2023 оны 213 дугаар тогтоол "Цалингийн хэмжээ, итгэлцүүр, түүнийг хэрэглэх төрийн байгууллагын жагсаалт, орон тооны дээд хязгаарыг тогтоох журам";

- Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоол “Цалингийн хэмжээ, итгэлцүүр, түүнийг хэрэглэх төрийн байгууллагын жагсаалт, орон тооны дээд хязгаарыг тогтоох журам”;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

Тус байгууллага нь дотоод аудитын нэгж, ажилтангүй. Байгууллагын үйл ажиллагаанд харьяалагдах дээд байгууллага болох Нийслэлийн засаг даргын дэргэдэх дотоод аудитын газар хяналт тавин ажилладаг бөгөөд тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүнс хангамж төв ОНӨААТҮГ нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хүнс хангамж төв ОНӨААТҮГ-ын захирлын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/34 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байна. Мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарт, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хүнс хангамж төв ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааны бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 36,232.0 мянган төгрөгөөр буюу 6.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

(мянган төгрөг)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	70,388.3	114,116.7	43,728.4
Дансны болон бусад авлага	5,325.9	15,982.0	10,656.1
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	164.1	164.1
Бараа материал	60,952.0	58,381.4	(2,570.6)
Үндсэн хөрөнгө	370,750.2	355,004.2	(15,746.0)
Биет бус хөрөнгө	34,675.5	34,675.5	-
Нийт хөрөнгө	542,091.9	578,323.9	36,232.0
Дансны болон бусад богино өр төлбөр	255,055.0	80,772.3	(174,282.7)
Урьдчилж орсон орлого	262,869.0	6,571.7	(256,297.3)
Хойшлогдсон татварын өр төлбөр	-	1,645.0	1,645.0
Бусад урт хугацаат өр төлбөр	-	246,439.7	246,439.7
Эздийн өмч	24,167.9	242,895.2	218,727.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	542,091.9	578,323.9	36,232.0

Дээрх хүснэгтээс харахад материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, эздийн өмчийн данс байна.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл нь 114,116.7 мянган төгрөг болж 43,728.4 мянган төгрөгөөр өссөн байна. Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэл 645.8 мянган төгрөг, харилцах дансны үлдэгдэл 113,470.9 мянган төгрөг байгаа бөгөөд банкны тулган баталгаажуулалт, тооллогын актаар баталгаажсан.

Авлага дансны үлдэгдэл нь 15,982.0 мянган төгрөг болж 10,656.1 мянган төгрөгөөр өссөн нь оны сүүлээр сургууль, цэцэрлэгт нийлүүлсэн хүнсний бараа, бүтээгдэхүүний авлагын үлдэгдэл өссөнөөс шалтгаалсан.

Урьдчилж төлсөн зардал, тооцоо дансны үлдэгдэл нь 164.1 мянган төгрөг байгаа нь Цахим капитал ХХК-руу шилжүүлсэн даатгалын төлбөр байна.

Бараа материалын үлдэгдэл нь 58,381.4 мянган төгрөг болж 2,570.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд 5,874,911.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 5,877,482.1 мянган төгрөгийн бараа материалыг борлуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл нь 355,004.2 мянган төгрөг болж 15,746.0 мянган төгрөгөөр буурсан нь 14,793.4 мянган хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэж, тайлант хугацааны элэгдлийн зардалд 30,539.5 мянган төгрөгийг тооцож бүртгэснээс тус тус шалтгаалсан.

Дансны болон богино хугацаат өр төлбөр нь 80,772.3 мянган төгрөг болж 174,282.7 мянган төгрөгөөр буурсан нь татварын байгууллагад төлсөн өглөгийн дүнгээр буурсан.

Урьдчилж орсон орлого нь 6,571.7 мянган төгрөг болж 256,297.3 мянган төгрөгөөр буурсан нь нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт болон нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр баригдаж ашиглалтад орсон хүнсний зориулалттай

агуулахын барилгыг НББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга"-ын дагуу урт хугацаат хойшлуулсан орлогоор залруулж толилуулсантай холбоотой.

Хойшлогдсон татварын өр төлбөр дансны үлдэгдэл 1,645.0 мянган төгрөг байгаа нь үндсэн хөрөнгийн санхүүгийн тайлангийн зорилгоор элэгдүүлэх хугацаа болон татварын зорилгоор элэгдүүлэх хугацааны түр зөрүүнээс үүсэх хойшлогдсон татварыг бүртгэлд тусгасантай холбоотой.

Эздийн өмчийн данс нь 242,895.2 мянган төгрөг болж, 218,727.3 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн нөөц 14,793.4 мянган төгрөг, тайлант үеийн ашиг 203,933.9 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Хүнс хангамж төв ОНӨААТҮГ нь эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Нийслэлийн Засаг даргын 2023 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн А/688 тоот захирамжаар 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 8,912,505.7 мянган төгрөгөөр, нийт зардлыг 8,851,305.7 мянган төгрөгөөр, 61,200.0 мянган төгрөгийн ашигтай ажиллахаар тогтоосон. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 80,000.0 мянган төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 6,697,910.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 6,418,391.1 мянган төгрөгийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны зардал гарган, татварын өмнөх ашиг 279,519.4 мянган төгрөг байгаа бөгөөд татварын зардалд 28,731.5 мянган төгрөг тайлагнаж, 250,787.9 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 6,697,910.5 мянган төгрөг болж төлөвлөснөөс 2,214,595.2 мянган төгрөг буюу 24.8 хувиар буурсан нь анх борлуулалтын орлогоо төлөвлөхдөө Сонгинохайрхан дүүргийн цэцэрлэг, сургуулийн хүүхдийн норм тоог үндэслэн гаргасан боловч зарим байгууллагууд цахимаас худалдан авалт хийсэнтэй холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 6,418,391.1 мянган төгрөг болж төлөвлөснөөс 2,424,024.4 мянган төгрөг буюу 27.4 хувиар дутуу зарцуулагдсан нь орлогын бууралттай холбоотой байна. Нийт зардлын 90.7 хувь нь буюу 5,820,729.6 мянган төгрөг нь борлуулсан бүтээгдэхүүний өртөг байна. Тайлант хугацаанд Боловсрол, шинжлэх ухааны яамнаас ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах, зорилгоор хичээлийн жилийн үргэлжлэх хугацаанд Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хуульд зааснаар ерөнхий гэрээний зарчмаар цахим худалдан авалтаас худалдан авалтаа хийх чиглэлийн дагуу цэцэрлэг, сургуулиуд цахим худалдан авалт хийснээс хүнсний бараа, бүтээгдэхүүний худалдан авалт багасаж, борлуулсан бүтээгдэхүүний өртөг төлөвлөгөөнөөс 2,179,550.3 мянган төгрөг буюу 27.2 хувиар буурсан байна.

Тайлант онд цэвэр ашиг 250,787.9 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 189,587.7 мянган төгрөгөөр илүү байгаа нь цалин, ур чадварын нэмэгдэл, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг төлөвлөхдөө батлагдсан бүтэц орон тоонд тулгуурлан 25 ажилтнаар төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 3 орон тоо дутуу ажиллаж цалин, урамшуулал, нийгмийн даатгалын зардлыг 165,406.2 мянган төгрөгөөр, шатахууны зардлыг 15,764.6 мянган төгрөгөөр, албан томилолтын зардлыг 8,000.0 мянган төгрөгөөр, шагнал урамшууллын зардлыг 8,000.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь нөлөөлжээ.

НӨХГ-т тайлант онд ногдол ашгийн 50,210.8 мянган төгрөг, данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөөс хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулсны орлогын 30 хувь буюу 18.0 мянган төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

3.5.1 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус байгууллага нь тайлант онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд Сонгинохайрхан дүүргийн цэцэрлэг, сургуулийн үдийн хоолны хүнсний бүтээгдэхүүний зардалд 6,619,802.7 мянган төгрөгийн 21 багц, хүнсний бүтээгдэхүүн түгээлтийн автомашин худалдан авах зардалд 80,000.0 мянган төгрөгийн нээлттэй тендер, цэцэрлэг, сургуулийн үдийн хоолны давсны зардалд 8,400.0 мянган төгрөг мөн аж ахуйн барааны зардалд 9,249.6 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийхээр нийт 6,717,451.3 мянган төгрөг баталсан байна. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тайлант хугацаанд тодотгол хийгээгүй.

Гүйцэтгэлээр цэцэрлэг, сургуулийн үдийн хоолны хүнсний бүтээгдэхүүний зардалд 6,013,797.8 мянган төгрөг буюу 90.8 хувиар, үдийн хоолны давс болон ахуйн барааны зардалд 19,639.8 мянган төгрөг буюу 111.3 хувиар, хүнсний бүтээгдэхүүн түгээлтийн автомашин худалдан аваагүй, нийт 6,033,437.6 мянган төгрөг буюу 89.8 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж 684,013.7 мянган төгрөг хэмнэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хүнс хангамж төв ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг хугацаанд нь төлж барагдуулж байх, байгууллагын дансанд бүртгэлтэй байгаа үл хөдлөх хөрөнгийг татварын байгууллагад бүртгүүлэх, хөрөнгийг шинж чанараас нь хамруулан зөв дансанд бүртгэж тайлагнах, тушаал шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэх, татварын байгууллагатай холбоотой өр, авлагыг тухай бүр тооцоо нийлж бүртгэлийн дүнтэй тулгаж байх, шилэн дансны нэгдсэн системд мэдээллийг цаг тухай бүр үнэн зөв оруулж байх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Солид юнити аудит ХХК-ийн аудитор Ү.Цэцэгмаа, аудиторын туслах Э.Нямдорж, А.Анужин нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтын менежер Н.Тунгалаг, гүйцэтгэх захирал Э.Мөнхтогтох нар хэрэгжүүлж, НТАГ-ын Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн аудитын менежер Я.Алтанцэцэг, хэлтсийн дарга Х.Түвшинбаяр нар дараагийн шатны чанарын хяналтыг хэрэгжүүлсэн.

Хүнс хангамж төв ОНӨААТҮГ нь 2023 оны санхүүгийн тайланг Солид юнити аудит ХХК-д 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 35 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 5,346,247.3 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 106,924.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь 80,193.7 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хангамж болон үйл ажиллагаанд тавих хязгаарлалт, хэмнэлтийн горимыг мөрдөж тус онд батлагдсан орон тоо, бүтцийн хүрээнд 3 орон тоо дутуу ажиллаж цалингийн зардалд 41,745.6 мянган төгрөг, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан хүнсний бүтээгдэхүүн түгээлтийн автомашин худалдан авах зардал 80,000.0 мянган төгрөгийг тус тус хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 8 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хүнс хангамж төв ОНӨААТҮГ нь 2023 онд нийт 13,841,892.8 мянган төгрөгийн, 772 мэдээллийг Шилэн дансны цахим хуудсанд ил тод байршуулахаас 489,649.3 мянган төгрөгийн 25 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Үүнд:

- Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгааны 8, 11 дүгээр сарын мэдээлэл, дараа жилийн зорилтот түвшин болон санхүүгийн хагас жилийн тайлан, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 263,176.5 мянган төгрөгийн 4 гүйлгээ, орлогын 226,472.8 мянган төгрөгийн 17 гүйлгээг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.10-д "Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар тогтмол мэдээлнэ" гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг хуульд заасан хугацаанд байршуулж ажиллах албан шаардлага хүргүүллээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 45 тоот тогтоол, Нийслэлийн засаг даргын 2022 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн А/872 тоот захирамжаар хүнсний зориулалттай агуулахын барилгыг (262,869.0 мянган төгрөг) хүлээн авч данс бүртгэлд тусгасан боловч үл хөдлөх хөрөнгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлж, ногдох албан татвар төлөөгүй байна. Энэ нь Үл хөдлөх хөрөнгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд" нь үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар төлөгч байна", мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан үнэлгээнээс аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал тухайн хөрөнгийн байршил, зориулалт, хэмжээ, зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн байдлыг харгалзан 0.6-2.0 хувиар тооцож ногдуулна" гэж заасан заалтуудтай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бүртгэлд тусгагдсан байгаа хүнсний зориулалттай агуулахын барилгыг үл хөдлөх хөрөнгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлэн, ногдуулсан татварыг хуулийн хугацаанд нь төлж байх зөвлөмж хүргүүллээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалт, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгадагч байгууллагын 2023 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд нийт 288,556.8 мянган төгрөгийн 7 алдаа, зөрчил илэрснээс 283,840.3 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 4,716.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмжийг өгснөөс хүнсний зориулалттай агуулахын барилгыг үл хөдлөх хөрөнгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлж, татвар төлөх талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй тул жилийн эцсийн асуудлын бүртгэлд тусгалаа.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 50 хувьтай байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	-	1	-	50.0
Нийт дүн	2	-	1	-	50.0

Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй тул албан шаардлага өглөө.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 237,501.5 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Залруулсан алдаа:

- Тайлант хугацаанд хойшлуулсан НӨАТ-ын авлага 2,957.0 мянган төгрөгийг татвар, НДШ-ийн авлагаар толилуулсан нь НББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын Хавсралт 1 "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар" заалттай нийцээгүй, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Тайлант хугацаанд ААНОАТ-ын өр төлбөрт төлсөн 13,069.8 мянган төгрөгийг НӨАТ-ын өр төлбөрийн үлдэгдэл дүнгээс бууруулан бүртгэсэн нь НББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 15.2-; "нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулах" заалтуудтай нийцээгүй ангилал батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Ажилчдад олгосон хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмж 561.8 мянган төгрөгийг НДШ-ийн зардал дансанд бүртгэсэн нь НББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын Хавсралт 1 "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар" заалттай нийцээгүй, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- НӨХГ-т төвлөрүүлсэн ногдол ашгийн төлбөрөөс 5,021.1 мянган төгрөгийн суутгасан ОАТ-ын өглөг бүртгээгүй байгаа нь Санхүүгийн тайлагналын онолын үзэл баримтлал 2.16, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" заалттай нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг 196,683.5 мянган төгрөгийг тайлант үеийн ашгаар толилуулсан нь НББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга"-ын 99, 102-р параграф, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4 "үнэн зөв байх", Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын Хавсралт 1 "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар" заалтуудтай нийцээгүй тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Үндсэн хөрөнгийн санхүүгийн тайлангийн зорилгоор элэгдүүлэх хугацаа болон татварын зорилгоор элэгдүүлэх хугацааны түр зөрүүнээс үүсэх хойшлогдсон татварыг тооцоолж 1,462.6 мянган төгрөгийг бүртгэлд тусгаагүй нь НББОУС 12 "Орлогын албан татвар"-ын дагуу түр зөрүүгээс үүсэх хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрч бүртгэх", Сангийн сайдын 2020 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 144 тоот тушаалаар "Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах журам"-тай нийцээгүй үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

- Тайлант онд хавсран ажилласан ажилтнуудын цалинг 605.8 мянган төгрөгөөр зөрүүтэй олгосон нь Санхүүгийн тайлагналын онолын үзэл баримтлал 2.16, Хөдөлмөрийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.5-д "Ажил олгогч түр ажил үүргийг гүйцэтгүүлэхээр ажилтныг цагаар ажиллуулж, гүйцэтгэсэн ажил, ажилласан цагт нь тохирсон цалин хөлсийг тухай бүр тооцож олгоно" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- НӨХГ-ын шийдвэрийн дагуу үлдэгдэл өртөггүй болсон хөрөнгүүдийн ашиглалтын хугацааг сунгаж бүртгэлд тусгахдаа элэгдлийн зардлыг 9,437.2 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн нь НББОУС-16 Үндсэн хөрөнгө, 60, 61-р параграф, НӨХГ-ын даргын 2023 оны 11 дүгээр сарын 9-ны өдрийн А/351 тоот тушаал, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4 "үнэн зөв байх" заалтуудтай нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Тайлант хугацаанд борлуулалт маркетингийн зардалд бүртгэх 5,876.6 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг ерөнхий удирдлагын зардалд бүртгэсэн нь НББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын Хавсралт 1 "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар" заалттай нийцээгүй, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- НӨХГ-ын шийдвэрээр актлах хөрөнгийн жагсаалтад орсон 123.0 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хасаагүй нь НББОУС-16 Үндсэн хөрөнгө, 67-р параграф, НӨХГ-ын даргын 2023 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн А/351 тоот тушаалтай нийцээгүй нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ААНОАТ-ын зардлыг 1,703.1 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн нь Санхүүгийн тайлагналын онолын үзэл баримтлал 2.16, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4 "үнэн зөв байх" заалттай нийцээгүй эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 21,306.6 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил нь 21,306.6 мянган төгрөг байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Татвар, шимтгэлийн өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант оны эцэст татвар, шимтгэлийг хугацаанд нь төлж барагдуулаагүй ААНОАТ-ын өр 15,668.2 мянган төгрөг, НӨАТ-ын өр 51,315.9 мянган төгрөг, ХХОАТ-ын өр 8,482.9 мянган төгрөг, НДШ-ийн өр 609.2 мянган төгрөг, нийт 76,076.2 мянган төгрөгийн өр төлбөрт татвар, шимтгэлийг хугацаанд нь төлөөгүйн торгуульд 2,586.6 мянган төгрөг төлөхөөр байна. Энэ нь ААНОАТ-н тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-д "Энэ хуулийн 25.1-д заасан урьдчилан тодорхойлсон

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хуваарийн дагуу сар бүр төлөх татвараа сар бүрийн 25-ны дотор, улирлын эцэст хийсэн тооцооны дагуу татвараа дараа улирлын эхний сарын 20-ны дотор, жилийн эцэст хийсэн эцсийн тооцооны дагуу татвараа дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор төсөвт төлнө”, Зөрчлийн тухай хуулийн 11.19.1-д “Татварыг хугацаанд нь төлөөгүй бол төлөгдөөгүй татварын дүнд хугацаа хэтэрсэн хоног тутамд 0.1 хувьтай тэнцэх хэмжээний торгууль ногдуулна” гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Татвар, шимтгэлийн өр төлбөрийг хуулийн хугацаанд нь төлж барагдуулж байх, цаашид зөрчлийг давтан гаргахгүй ажиллах.

2. Борлуулалтын орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллагын Захирлын зөвлөлийн 2023 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн хурлаар 2023 оны хичээлийн шинэ жилд Сонгинохайрхан дүүргийн цэцэрлэг, сургуульд нийлүүлэх хүнсний бараа бүтээгдэхүүний үнийг шинэчлэн баталсан. Уг батлагдсан үнээс 30 нэр төрлийн 561 ширхэг бараа, бүтээгдэхүүнийг сургууль, цэцэрлэгт худалдан борлуулахдаа 2,954.6 мянган төгрөгөөр илүү борлуулсан байна. Энэ нь Захирлын зөвлөлийн 2023 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн хурлын шийдвэрээр батлагдсан “2023 оны хичээлийн шинэ жилийн бараа бүтээгдэхүүний борлуулалтын үнэ”-ийн жагсаалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид байгууллагын удирдах албан тушаалтан болон удирдах дээд байгууллага, зөвлөлөөс гаргаж баталсан тушаал, шийдвэрийг дагаж мөрдөх, үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллах нь зүйтэй.

3. Тооцооны үлдэгдлийн зөрүүтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллагатай холбоотой татварын өр, авлагын үлдэгдлийг тайлант хугацааны эцэст татварын байгууллагаар гаргуулан авсан татварын өр, авлагын үлдэгдлийн дүнг тодорхойлсон тодорхойлолтын дүнтэй тулган шалгахад байгууллагын бүртгэлд тусгасан өр, авлагын үлдэгдэл 15,110.9 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулах”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; заалтуудтай нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Татварын байгууллагатай тооцоо нийлж, татварын тодорхойлолт, бүртгэлийн хооронд үүссэн зөрүүгийн шалтгааныг тогтоож шаардлагатай бол зохих залруулгыг хийх.

4. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант хугацаанд худалдан авсан 654.5 мянган төгрөгийн Epson-L3218 маркийн принтерийг бараа материалын дансанд бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “Үнэн зөв байх”, Сангийн сайдын 388 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4 дүгээр зүйлийн 4.15-д “Бараа материал гэдэг нь байгууллагын хэвийн үйл ажиллагааны явцад хэрэглэгдэх материал буюу хангамжийн зүйлс, худалдах зориулалтаар хадгалагдаж байгаа (улсын нөөцийн бараа зэрэг) бэлэн

бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ, үйлдвэрлэлийн процесст байгаа хагас боловсруулсан бүтээгдэхүүн зэрэг болно” гэсэн заалттай нийцээгүй, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид хөрөнгийг холбогдох стандартын дагуу ашиглалтын хугацаа, шинж чанарыг харгалзан зөв ангилан бүртгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)													
Алдааны товч утга		Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
Хойшлуулсан НӨАТ-ын авлагыг татвар, НДШ-ийн авлагаар толилуулсан.		1	2,957.0					1	2,957.0				
Тайлант хугацаанд ААНОАТ-ын өр төлбөрт төлсөн төлбөрийг НӨАТ-ийн өр төлбөрийн үлдэгдэл дүнгээс бууруулан бүртгэсэн.		1	13,069.8					1	13,069.8				
Ажилчдад олгосон хөдөлмөрийн чадавч алдсаны тэтгэмжийн зардлыг НДШ-ийн зардал дансанд бүртгэсэн.		1	561.8					1	561.8				
НӨХГ-т төвлөрүүлсэн ногдол ашгийн төлбөрөөс суутгасан ОАТ-ын өглөг бүртгээгүй.		1	5,021.1					1	5,021.1				
Өмнөх үеийн хуримтлагдсан ашгийг тайлант үеийн ашгаар толилуулсан.		1	196,683.5					1	196,683.5				
Үндсэн хөрөнгийн санхүүгийн тайлангийн зорилгоор болон татварын зорилгоор элэгдүүлэх хугацааны түр зөрүүнээс үүсэх хойшлогдсон татварыг тооцоолж бүртгэлд тусгаагүй.		1	1,462.6					1	1,462.6				
Тайлант онд хавсран ажигласан ажилтнуудын цалинг зөрүүтэй олгосон.		1	605.8					1	605.8				
НӨХГ-н шийдвэрийн дагуу үлдэгдэл өртөггүй болсон хөрөнгүүдийн ашиглалтын хугацааг сунгаж бүртгэлд тусгахдаа элэгдлийн зардлыг илүү бүртгэсэн.		1	9,437.2					1	9,437.2				
Тайлант хугацаанд борлуулалт маркетингийн элэгдлийн зардлыг ерөнхий удирдлагын элэгдлийн зардалд бүртгэсэн.		1	5,876.6					1	5,876.6				
НӨХГ-ын шийдвэрээр актлах хөрөнгийн жагсаалтад орсон хөрөнгийг данснаас хасаагүй.		1	123.0					1	123.0				
ААНОАТ-ын зардлыг зөрүүтэй бүртгэсэн.		1	1,703.1					1	1,703.1				
Дүн		11	237,501.5					11	237,501.5				

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хойшлуулсан НӨАТ-ын авлагыг татвар, НДШ-ийн авлагаар толилуулсан.	1	2,957.0					1	2,957.0				
Тайлант хугацаанд ААНОАТ-ын өр төлбөрт төлсөн төлбөрийг НӨАТ-ийн өр төлбөрийн үлдэгдэл дүнгээс бууруулан бүртгэсэн.	1	13,069.8					1	13,069.8				
Ажилчдад олгосон хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмжийн зардлыг НДШ-ийн зардал дансанд бүртгэсэн.	1	561.8					1	561.8				
НӨХГ-т төвлөрүүлсэн ногдол ашгийн төлбөрөөс суутгасан ОАТ-ын өглөг бүртгээгүй.	1	5,021.1					1	5,021.1				
Өмнөх үеийн хуримтлагдсан ашгийг тайлант үеийн ашгаар толилуулсан.	1	196,683.5					1	196,683.5				
Үндсэн хөрөнгийн санхүүгийн тайлангийн зорилгоор болон татварын зорилгоор элэгдүүлэх хугацааны түр зөрүүнээс үүсэх хойшлогдсон татварыг тооцоолж бүртгэлд тусгаагүй.	1	1,462.6					1	1,462.6				
Тайлант онд хавсран ажилласан ажилтнуудын цалинг зөрүүтэй олгосон.	1	605.8					1	605.8				
НӨХГ-н шийдвэрийн дагуу үлдэгдэл өртөггүй болсон хөрөнгүүдийн ашиглалтын хугацааг сунгаж бүртгэлд тусгахдаа элэгдлийн зардлыг илүү бүртгэсэн.	1	9,437.2					1	9,437.2				
Тайлант хугацаанд борлуулалт маркетингийн элэгдлийн зардлыг ерөнхий удирдлагын элэгдлийн зардалд бүртгэсэн.	1	5,876.6					1	5,876.6				
НӨХГ-ын шийдвэрээр актлах хөрөнгийн жагсаалтад орсон хөрөнгийг данснаас хасаагүй.	1	123.0					1	123.0				
ААНОАТ-ын зардлыг зөрүүтэй бүртгэсэн.	1	1,703.1					1	1,703.1				
Дүн	11	237,501.5					11	237,501.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант хугацааны эцэст татвар, шимтгэлийг хугацаанд нь төлж барагдуулаагүй нийт 76,076.2 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлээс зөрчлийн тухай хуулиар торгууль ногдохоор байна.	1	2,586.6					1	2,586.6				
Захирлын зөвлөлийн хурлын шийдвэрээр батлагдсан үнээс 30 нэр төрлийн 561 ширхэг бараа, бүтээгдэхүүнийг сургууль, цэцэрлэгт худалдан борлуулахдаа илүү үнээр борлуулсан.	1	2,954.6					1	2,954.6				
Татварын цахим системээс гарч буй татварын авлага, өглөгийн тодорхойлолтын дүн байгууллагын бүртгэлд тусгасан өр, авлагын үлдэгдэл дүнгээс зөрүүтэй.	1	15,110.9					1	15,110.9				
Тайлант хугацаанд худалдан Epson-L3218 маркийн принтерийг бараа материалын дансанд бүртгэсэн байна.	1	654.5					1	654.5				
Дүн	4	21,306.6					4	21.306.6				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансны цахим хуудсанд 489,649.3 мянган төгрөгийн 25 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	1	489,649.3	1	489,649.3		
Дүн	1	489,649.3	1	489,649.3		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Хүнсний зориулалттай агуулахын барилгыг хүлээн авч данс бүртгэлд тусгасан боловч үл хөдлөх хөрөнгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлж, ногдох албан татвар төлөөгүй байна.	1	-			1	-
Дүн	1	-			1	-
Нийт дүн	2	489,649.3	1	489,649.3	1	-